


Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал /2017 оны 2 дугаар сар/

Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчимд агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), $\text{PM}_{2.5}$ тоосонцор, PM_{10} тоосонцор, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), озон (O_3) болон цаг уурын үзүүлэлтүүдийг автомат болон автомат бус багажаар хэмжин тодорхойлж байна.

2017 оны 2 дугаар сард хэмжигдсэн агаар бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг 2016 оны 2 дугаар сартай харьцуулахад PM_{10} тоосонцрын дундаж агууламж $23\text{мкг}/\text{м}^3$ -ээр буюу **14%**-аар, $\text{PM}_{2.5}$ тоосонцрын дундаж агууламж $35\text{мкг}/\text{м}^3$ -ээр буюу **26%**-аар, хүхэрлэг хийн дундаж агууламж $33\text{мкг}/\text{м}^3$ -ээр буюу **45%**-аар тус тус бага байсан бол азотын давхар ислийн дундаж агууламж $11\text{мкг}/\text{м}^3$ -ээр буюу **23%**-аар их байсан байна. Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарыг агаар бохирдуулах бодис тус бүрээр дараах хэсэгт харуулав.

PM10 тоосонцор




Зураг 1. Хүйтний улирлын PM_{10} тоосонцрын сарын дундаж агууламж, 2012-2017он

Агаарын чанарын суурин нийт харуулуудын дүнгээр PM_{10} тоосонцрын 2017 оны 2-р сарын дундаж агууламж $153\text{мкг}/\text{м}^3$ байгаа нь өмнөх оноос 14%-аар бага байна (Зураг 1).

PM_{10} тоосонцрын 24 цагийн дундаж агууламжийг 2017 оны 2 дугаар сард 11 цэгт нийт 298 удаа хэмжилт хийснээс 218 удаа буюу 73% нь Агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламж /цаашид АЧС дахь ХА гэх/-аас давсан.

2 дугаар сард 24 цагийн дунджийн хамгийн их агууламж 100 айл орчимд $763\text{мкг}/\text{м}^3$ хүрсэн нь АЧС дахь ХА-тай харьцуулахад 7.6 дахин их байна.

PM2.5 тоосонцор




Зураг 2. Хүйтний улирлын PM2.5 тоосонцрын сарын дундаж агууламж, 2012-2017он

Агаарын чанарын суурин харуулуудын дүнгээр PM2.5 тоосонцрын 2016 оны 2-р сарын дундаж агууламж 98мкг/м^3 -д хүрсэн бөгөөд өмнөх оноос 26%-аар бага байна (Зураг 2).

PM2.5 тоосонцрын 24 цагийн дундаж агууламжийг 2017 оны 2 дугаар сард нийт 7 цэгт 187 удаа тодорхойлсноос 170 удаа буюу 91% нь АЧС дахь ХА-аас давсан тохиолдол ажиглагдсан.

24 цагийн дунджийн хамгийн их агууламж Баянхошуу орчим 713мкг/м^3 хүрч АЧС дахь ХА-тай харьцуулахад 14.3 дахин их байна.

Азотын давхар исэл (NO_2)




Зураг 3. Хүйтний улирлын азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2012-2017он

Агаарын чанарын суурин нийт харуулуудын дүнгээр азотын давхар ислийн 2017 оны 2-р сарын сарын дундаж агууламж 59мкг/м^3 байгаа нь өмнөх оноос 23%-аар их байна (Зураг 3).

Азотын давхар ислийн 24 цагийн дундаж агууламжийг 2017 оны 2 дугаар сард нийт 13 цэгт 331 удаа тодорхойлсноос 171 удаа буюу 52%-д нь АЧС дахь ХА-аас давсан.

24 цагийн дунджийн хамгийн их агууламж 13-р хороолол орчимд 176мкг/м^3 хүрсэн нь АЧС дахь ХА-тай харьцуулахад 3.5 дахин их байна.

Хүхэрлэг хий (SO₂)



Зураг 4. Хүйтний улирлын хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2012-2017он

Агаарын чанарын суурин харуулуудын дүнгээр хүхэрлэг хийн 2017 оны 2-р сарын дундаж агууламж 42мкг/м³ хүрсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 45%-аар бага байлаа (Зураг 4).

Хүхэрлэг хийн 24 цагийн дундаж агууламжийг 2017 оны 2 дугаар сард нийт 14 цэгт 360 удаа хэмжилт хийснээс 152 удаа буюу 42%-д нь АЧС дахь ХА-аас давсан тохиолдол ажиглагдсан.


24 цагийн дунджийн хамгийн их агууламж Зурагт орчимд 263мкг/м³ хүрсэн нь АЧС дахь ХА-тай харьцуулахад 5.3 дахин их байна.

2017 оны 2 дугаар сарын агаарын чанарыг индексээр үнэлэхэд


Улаанбаатар хотын агаарын чанарыг хянах автомат суурин харуулуудын 2017 оны 2 дугаар сарын дүнг индексээр тооцон тухайн орчны агаарын чанарыг үнэлэн дараахи хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 1. Агаарын чанарын индексийн түвшин, өдрийн тоо

	Цэвэр	Хэвийн	Бага зэргийн бохирдолтой	Дунд зэргийн бохирдолтой	Их бохирдолтой	Маш их бохирдолтой
Нисэх	-	3	11	8	-	-
Толгойт	-	-	12	4	4	8
Баянхошуу	-	1	5	8	3	11
Зурагт	-	-	3	7	6	9
Амгалан	-	4	17	7	-	-
Баруун 4 зам	-	-	20	6	2	-
13-р хороолол	-	-	17	11	-	-
100 айл	-	1	14	7	1	4
Цахилгаан станц	-	3	22	3	-	-
Ургах наран хороолол	1	16	11	-	-	-



Зураг 5. Улаанбаатар хотын 2017 оны 2-р сарын агаарын чанарын индекс, %-аар



Зураг 6. Улаанбаатар хотын агаар дахь бохирдуулах бодисуудын агаарын чанарын индекс, 2017 оны 2-р сар

Хүснэгт 1. 2017 оны 2-р сарын агаарын чанарын индекс

Он, сар, өдөр, гариг	Нисэх	Толгойт	Зурагт	Баянхошуу	100 айл	13-р хороолол	Баруун 4 зам	Амгалан	Цахилгаан станц	Ургах наран хороолол	
1/2/2017	Ням	350	902	730	1358	763	288	476	256	189	124
2/2/2017	Даваа		722	578	1132	560	266	246	182	132	106
3/2/2017	Мягмар		706		1426	669	296	270	252	186	100
4/2/2017	Лхагва		662		940	373	352	440	304	240	118
5/2/2017	Пүрэв		472		764	294	352	214	172	141	88
6/2/2017	Баасан		198	308	194	116	302	194	118	86	63
7/2/2017	Бямба		154	434	200	102	238	186	138	117	56
8/2/2017	Ням	260	554	628	656	277	284	326	274	254	116
9/2/2017	Даваа	346	640	662	1070		268	283	284	219	116
10/2/2017	Мягмар	270	596	570	954	532	248	218	206	136	98
11/2/2017	Лхагва	252	484	432	824	419	230	218	180	123	82
12/2/2017	Пүрэв	294	614	550	1044	381	250	238	246	187	104
13/2/2017	Баасан	166	430	536	818	392	232	230	98	104	61
14/2/2017	Бямба	254	440	548	452	298	244	282	210	217	100
15/2/2017	Ням	76	106	196	80	116	174	182	99	74	56
16/2/2017	Даваа	152	318	436	204	156	212	204	220	148	82
17/2/2017	Мягмар	244	358	448	408	253	228	234	194	214	124
18/2/2017	Лхагва	154	200	268	362	234	202	176	126	124	82
19/2/2017	Пүрэв	84	118	166	114	87	152	146	93	72	56
20/2/2017	Баасан	174	204	384	378	201	232	192	94	106	44
21/2/2017	Бямба	182	226	294	300	242	220	200	174	139	80
22/2/2017	Ням	162	236	286	306	206	232	192	190	164	110
23/2/2017	Даваа	208	230	406	420	222	238	210	166	161	132
24/2/2017	Мягмар	298	258	478	358	198	252	280	298	289	156
25/2/2017	Лхагва	238	258	592	322	205	254	320	314	278	136
26/2/2017	Пүрэв	180	214	368	320	240	244	210	188	147	78
27/2/2017	Баасан	194	200	368	264	200	252	200	178	148	100
28/2/2017	Бямба	74	102	156	104	150	198	164	159	103	91

Индексийн тоон үзүүлэлт	Агаарын чанар	Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл
0 - 50	Цэвэр	Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
51-100	Хэвийн	Агаарын чанар шаардлага хангах боловч, зарим бохирдуулах бодисын нөлөөлөлд хэт мэдрэг хүмүүс өртөж болно. Тухайлбал, озон, нарийн ширхэглэгт тоосонцрын нөлөөллийн улмаас хэт мэдрэг хүмүүст амьсгалын замын өвчний шинж тэмдэг илрэх магадлалтай.
101 – 250	Бага зэргийн бохирдолтой	Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ. Зүрх судас, амьсгалын замын архаг өвчтэй, ялангуяа гуурсан хоолойн багтраа өвчтэй хүмүүс нөлөөлөлд илүү өртөнө.
251 – 400	Дунд зэргийн бохирдолтой	Нийт хүн амын эрүүл мэндэд бага зэргийн сөрөг нөлөөлөл илэрч эхэлнэ. Хэт мэдрэг хүмүүсийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл хүндээр илэрнэ.
401 – 500	Их бохирдолтой	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд мэдэгдэхүйц нөлөөлөл илэрнэ.
501<	Маш их бохирдолтой	Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл илэрнэ.